

ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

С.Шаравдорж*

* Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн

Түлхүүр үг: орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ОНМХ-ийн тогтолцоо, шилжилтийн үеийн орон нутгийн хэвлэл мэдээлэл, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь Монголын ОНМХ-ийн тогтолцоонд томоохон байр суурь эзэлдэг өөрийн онцлогтой, өвөрмөц бүтэцтэй салбар юм.

Эдүгээ Монгол улсад мөрдөж байгаа засаг захиргааны бүтцээр авч үзвэл нийслэл Улаанбаатарыг оруулаад бүх хүн ам, газар нутгийг оршин суугаа засаг захиргааны харьяаллаар нь орон нутаг гэсэн ойлголтод багтааж байгаа юм.

Орон нутгийн мэдээлэл нь тухайн иргэний харьяалагдаж байгаа засаг захиргаа, оршин суугаа нутаг дэвсгэрийн хүрээнд болж байгаа үйл явдлын хамгийн чухал мэдээллийг өөртөө агуулсан байдгаараа онцлогтой.

Орон нутгийн хэвлэл мэдээлэл ижил төстэй олон жижиг хэсгээс бүрдэх

боловч нийлбэр дүнгээрээ олон мянган уншигч, үзэгч, сонсогчдыг татаж, асар өргөн хүрээг хамардгаараа төвийн хэвлэл мэдээллээс давуу талтай.

1970-1980-аад оны орон нутгийн хэвлэл мэдээллийн байдал

1990 оноос өмнө социалист тогтолцооны үед орон нутагт радио телевиз бие даан үүсч хөгжөөгүй, Баян-Өлгийгөөс бусад аймагт зөвхөн сонин хэвлэл мэдээллийн гол хэрэгсэл нь болж байлаа. Бүх аймгийн сонинууд нам, захиргааны байгууллагынхаа ивээлд багтаж, тэндээс шууд санхүүжиж, МАХН-ын үзэл суртлын гол зэвсэг нь болж байв.

Манай орны газар зүйн байдал, хүн амын суурьшилтыг харгалзан нам, засгаас орон нутгийн сонин сэтгүүлийг бий болгож хөгжүүлэх асуудалд 1940-1950-иад оноос онцгой анхаарч эхэлжээ. Хамгийн алслагдсан Баян-Өлгий аймгийг "Жана Өмир" сонин, хожмоо казак хэлний радио нэвтрүүлэгтэй болгосон ба 1960-аад он гэхэд бүх аймаг, хотыг

өөрийн хэвлэлтэй болгосон байв. Нам засгаас орон нутгийн хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд дэс дараатай арга хэмжээ- нүүд авч хэрэгжүүлсний үр дүнд хөдөөгийн ард иргэд тогтмол мэдээлэл хүртэх боломжоор нэгэнт хангагдаад байлаа.

Шилдэг сэтгүүлчдэд улс төрийн боловсрол давхар олгож гадаад дотоодод сургах, аймгуудад томилох, хэвлэх үйлдвэрийн инженер техникийн ажилтнуудыг бэлтгэх, аймаг бүрийг хэвлэх үйлдвэртэй болгох, редакциудыг байраар хангах, сонины хүргэлтийн системийг шуурхай болгох, идэвхитэн бичигчдийн сургалт зөвлөлгөөнийг зохион байгуулах зэрэг цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд аймаг бүрт 40 орчим сэтгүүлчид, уран бүтээлч, инженер техникийн ажилтнуудаас бүрдсэн мэргэжлийн баг, 60-100 хүртэл идэвхитэн бичигчдийн бүхэл бүтэн арми ажиллаж байв. Аймгуудын сонинууд АЗ-ын форматаар 4 нүүрээр 7 хоногт 2 удаа 5-13 мянган хувиар жилдээ 104-108 дугаар хэвлэгдэж байжээ.

Хэдийгээр орон нутгийн сонины энэ цогцолбор шинжтэй хүчирхэг бүтэц нь төвийн хэвлэл мэдээллээс дутахааргүй өргөн хүрээтэй, өөрийн давуу талуудтай байсан боловч, тухайн нийгмийн байгуулалттайгаа уялдсан сул талуудыг бас өөртөө агуулж байлаа. Энэ нь нөгөө л нэг намын үзэл суртлын хяналтанд бүрэн захирагдаж, түүнд үйлчилж ирсэн явдал, хоёрдугаарт, хэвлэл мэдээлэлд

хүчтэй хяналт (цензур) намын болон төрийн зүгээс ноёрхож байв. Гуравдугаарт, социалист нийгмийн нэгдсэн хатуу төлөвлөгөөнд захирагдан анхан шатны редакц, хэвлэх үйлдвэрийн хувьд бие даасан байдал алдагдаж санал, санаачлага гаргах, чөлөөт өрсөлдөөнд орох, орлогоороо зарлагаа нөхөх боломжгүй нөхцөлд ажиллаж байжээ.

Иймэрхүү бүтэц, дүр зурагтайгаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тогтолцоо 1990 онтой золгосон юм.

Шилжилтийн үеийн орон нутгийн хэвлэл мэдээллийн онцлог

Орон нутгийн сонины энэхүү бүтэц Монголд ардчилал, зах зээлийн харилцаа тогтож эхэлсэн 1990-ээд оны эхнээс задарч, эрч хүч нь сааран эхлээд намын харьяаллаасаа татгалзан аймгийн төр захиргааны хэвлэл хэлбэрээр нэг хэсэг оршин тогтносон боловч удаан үргэлжлээгүй юм. Энэ задрал нь нийгмийн харилцааны өөрчлөлтийн жам ёсны үзэгдэл байсан бөгөөд төвийн хэвлэлүүдийг ч энэ үзэгдэл тойроогүй билээ.

1980-аад оны сүүлчээр Монголд нийт 35 сонин тогтмол хэвлэгдэж байсны 21 нь орон нутгийн сонинууд байжээ.

1990-ээд оны дундуур хүмүүсийн улс төр, нийгмийн идэвхи сонирхол дээд цэгтээ хүрч, сонин хэвлэлийн "үер" бууж байлаа. 1998 оны 1-р сарын 0-ний байдлаар ХЗЯ-нд бүртгэлтэй сонины тоо 648-д хүрсэн байв¹.

Энэ үеэр орон нутагт ч олон сонин шинээр мэндэлж анхны радио,

телевизийн студиуд үүсч байлаа. Архангай аймгийн "Ойлгомжтой", "Архангайн үнэн", "Дээж мэдээ", Булган аймгийн "Булган хангай", "Дэвшил", Өмнөговь аймгийн "Говийн мэдээ", "Өнөөдрийн говь", Дарханы "Дархан", "Дарханы сонин", Хэнтий аймгийн "Хэнтийн мэдээ", Ховд аймгийн "Хаврын мэдээ", Увс аймгийн "Увсын амьдрал", Дорноговь аймгийн "Цаасан шувуу", Завхан аймгийн "Завханы мэдээ", Баянхонгор аймгийн "Баянхонгорын мэдээ", Дорнод аймгийн "Шинэ дорнод", Сэлэнгэ аймгийн "Сүхбаатарын туг", "Сэлэнгэ таймс", Өвөрхангай аймгийн "Өвөрхангайн амьдрал", Орхон аймгийн "Эрдэнэт" зэрэг сонинуудын анхны дугаарууд хэвлэгдэн гарч, уншигчиддаа хүрч байлаа. Гэвч эдгээр сонины ихэнхи

нь хөл дээрээ босч, тогтмол хэвлэл болж чадаагүй цөөн хэдэн дугаар гаргаад зогссон.

1999 оны 1-р сарын 1-ээс "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хууль хэрэгжиж эхэлснээр аймгийн Засаг захиргааны харьяалалд гарч байсан сонинууд татан буугдаж, зах зээлийн чөлөөт өрсөлдөөний таатай нөхцөл бүрдсэн хэдий ч тэр орон зайд сонин

эрхлэн гаргах боловсон хүчний боломж, мэдээлэл олж авах эрх зүйн орчин, орон нутгийн ард иргэдийн амьжиргааны төвшин, хэвлэл мэдээллийг амьдрал ахуйдаа ашиглах чадвар, дэд бүтцийн хөгжил гээд тоолж баршгүй олон бэрхшээлтэй тулгарч байлаа.

1990-ээс 2000 он хүртэл орон нутгийн хэвлэл мэдээллийн хувьд шилжилтийн он жилүүд байлаа.

«

1999 оны 1-р сарын 1-ээс "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хууль хэрэгжиснээс эхэлснээр аймгийн Засаг захиргааны харьяалалд гарч байсан сонинууд татан буугдаж, зах зээлийн чөлөөт өрсөлдөөний таатай нөхцөл бүрдсэн хэдий ч тэр орон зайд сонин эрхлэн гаргах боловсон хүчний боломж, мэдээлэл олж авах эрх зүйн орчин, орон нутгийн ард иргэдийн амьжиргааны төвшин, хэвлэл мэдээллийг амьдрал ахуйдаа ашиглах чадвар, дэд бүтцийн хөгжил гээд тоолж баршгүй олон бэрхшээлтэй тулгарч байлаа.

»

хойлж болох юм.

1. Хуучин тогтсон бүтэц задарч, сонинууд хэвлэгдэхээ больж, хэвлэх үйлдвэрүүд хувьчлагдсан.

2. Зах зээлийн ямар ч ойлголтгүй, бэлтгэлгүй байсан хэвлэл мэдээллийн ажилтнууд, мэргэжлийн боловсон хүчнүүд ихэнх нь хот хүрээ бараадан, зарим нь мал аж ахуй, газар тариалан эрхлэн амьдралаа залгуулах болсон.

3. Орон нутгийн төр захиргааны зүгээс хэвлэл мэдээлэлд анхаарал хандуулах боломж эрх зүйн хувьд ч, хөрөнгө санхүүгийн хувьд ч байхгүй болсон.

4. Сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагын хувьд орон нутагт анхаарал хандуулах нь байтугай өөрсдөө төвхнөж чадаагүй хүнд үе байлаа.

Үнэхээр шилжилтийн энэ он жилүүдэд орон нутгийн хэвлэл мэдээлэл "муужран" унасан нь үнэн бөгөөд өндийх сэхэх нь тодорхойгүй явсаар шинэ зуунтай золгосон юм. Харин энэ үеэр Монголд чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх зорилгоор Данийн вант улсын засгийн газраас хэрэгжүүлж байсан "Данида" төсөл орон нутгийн хэвлэл мэдээллийн хувь заяанд үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэснийг энд тэмдэглэн хэлэх хэрэгтэй.

Уг төслийн хүрээнд зохион байгуулагдаж байсан сургалт семинаруудад хөдөөгийн сэтгүүлчдийг өргөнөөр хамруулж, бүсийн чанартай сургалтуудыг олноор хийж, гадаад дотоодын мэргэжлийн багш нараар орчин үеийн сэтгүүл зүйн онолыг заалгаж, практик амьдрал дээр тулгарч байсан бэрхшээлүүдийг даван туулах арга замыг ярилцаж байсан нь хожмоо аймгуудын хэвлэл мэдээллийн байгууллагуудыг авч явах мэргэжлийн боловсон хүчний шинэ үеийг бэлтгэх эхлэл нь болсон юм.

Дани улсын Аархус хотын Их сургуулийн профессор, доктор Пол Эрик

Нилсон тухайн үеийн орон нутгийн хэвлэл мэдээллийн байдлыг дүгнэн хэлэхдээ: "Нийслэл хотод хэвлэл мэдээлэл өргөжин хөгжиж байхад хөдөө орон нутагт нөхцөл байдал урам хугарам байдалтай байна. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хувьд шилжилтийн үйл явцын яг дунд явж байна. Хэвлэл мэдээллийн хуучин тогтолцоо үгүй болж түүнийг орлох ямар нэгэн тогтвортой шинэ систем бий болоогүй байна.

Орон нутаг дахь хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал туйлын хангалтгүй, мэдээллийн энэ хязгаарлагдмал байдал нь хөдөө орон нутгийн нийгэм соёлын хөгжлийг хязгаарлаж байна" гэжээ.

Энэ дүгнэлт гашуун ч гэсэн үнэн байдлыг хэлсэн юм.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд

Орон нутгийн сонинуудын ирээдүй үнэхээр бүрхэг байсан энэ үед хөдөөгийн сэтгүүлчид нөхцөл байдлыг өөрчлөх гарц боломжийг хайж хамтран ажиллах, нэгдсэн зохион байгуулалтанд орох анхны алхмуудыг хийж эхэлсэн билээ.

МХХ-ийн мониторингийн албанаас 2001 оны 9-р сарын 18-20-нд Тэрэлжид "Орон нутгийн хэвлэл мэдээлэл ба мэдээлэл авах орчин" сэдэвт семинарыг зохион байгуулсан юм. Энэ уулзалт, семинар нь орон нутгийн хэвлэл мэдээллийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох анхны оролдлого, томоохон алхам

байлаа. Улмаар МХХ-ийн дэргэд Орон нутгийн хэвлэл мэдээллийг дэмжих "Ган үзэг" сан байгуулагдсан нь орон нутгийн гэх анхны байгууллага байлаа.

2002 оны эхнээс дан дангаараа оршин тогтнох боломжгүй болоод байсан хэд хэдэн аймгийн сонины эрхлэгч нар нэгдэн "Ховдын мэдээ", "Завхан", "Шинэ мэдээ", "Сэлэнгийн мэдээ", "Дорнод" сонинуудыг эрхлэн гаргах болсон нь хожим байгуулагдсан Орон нутгийн хэвлэл мэдээллийн нэгдсэн редакци МЭРИ төвийн үндэс суурийг тавьсан юм. МЭРИ гэдэг нь "Мэдээллийн эрин" гэсэн үгний товчилсон нэр бөгөөд тус төвд аймгуудын сонины эх бэлтгэгч нарыг сургах, сэтгүүлчдийг сургалт семинарт хамруулах, шинээр байгуулагдсан редакциудад арга зүйн тусламж үзүүлэх, төсөл хэрэгжүүлэх зэрэг олон хэлбэрийн ажлыг зохион байгуулж байв. Одоо тус төвийн бүрэлдэхүүнд Архангай, Булган, Өвөрхангай, Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Завхан, Сэлэнгэ, Дорнод, Баянхонгор, Ховд зэрэг 10 гаруй аймгийн сонины редакциуд багтан үйл ажиллагаа нь тогтмолжин сонины захиалгын тоо нэмэгдсээр байна.

Нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх, олон нийтийг мэдээллээр хангахад орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд чухал үүрэгтэйг харгалзан 20 шахам аймгийн сонины эрхлэгч нар 2004 онд Эрдэнэт хотод хуралдаж "Орон нутгийн сонины холбоо" ТББ-ыг байгуулсан билээ. Улмаар аймгуудын

радио телевизийн сэтгүүлчдийн уран бүтээлчдийн санаачлагыг дэмжиж, 2005 оны 2-р сард "Орон нутгийн сонины холбоо"-ны үйл ажиллагааг өргөтгөн "Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо"-г байгуулсан.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бүх радио, телевиз, сониныг нэгтгэсэн төрийн бус байгууллага бөгөөд тэнд ажиллагсдын эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагааг нь дэмжих мэргэжлийн гол байгууллага юм.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо нь Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монголын Хэвлэлийн Хүрээлэн, "Чөлөөт хэвлэл" сан зэрэг сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулж орон нутагт ажиллаж байгаа сэтгүүлчдийг сургалт семинарт хамруулах, харилцан туршлага солилцох, хамтран ажиллахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Ийнхүү сүүлийн жилүүдэд орон нутгийн сэтгүүлчид хэн нэгний дэмжлэг тусалцааг харан хүлцэнгүй суух биш, харин хамтран нэгдэж, ухаанаа уралдуулж, нөөц бололцоогоо дайчлан ажиллах болсны үр дүнд нааштай ахиц, дэвлүүд гарч, орон нутгийн хэвлэл мэдээлэл нийтдээ сэргэх хандлагатай боллоо.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал

Орон нутгийн хэвлэл мэдээллийн өнөөгийн байдлыг хөдлөшгүй тоо

баримтаар илэрхийлэх, цөөн үгээр тодорхойлох боломжгүй юм. Учир нь улс орны хөгжил, цагийн урсгалыг даган байнга хувьсан өөрчлөгдөж байгаа эмзэг салбарын нэг нь орон нутгийн хэвлэл мэдээлэл болоод байна. Иймд сүүлийн хоёр жилийн байдлаар орон нутгийн хэвлэл мэдээлэл ямар төвшинд байгааг төрөл тус бүрээр нь авч үзье.

А. Сонин. 2001 оны 6-р сарын байдлаар орон нутагт нийтдээ 23 сонин алдаг оног гарч байснаас эхний хагас жилд 9 сонин шинээр мэндэлж байжээ. Эдгээр сонинуудын нэг удаагийн хэвлэлтийн тоо 500-1800-гийн хооронд хэлбэлзэж байсан бөгөөд ихэнхи нь 1000 хүрэхгүй хувиар тарж байв. 2001 оны эхний хагас жилд 284 мянган ширхэг орон нутгийн сонин борлогдсон нь Монголын нийт сонины дөнгөж 2,6 хувийг эзэлж байв. Бас нэг сонирхолтой тоо баримт бол аймгийн сонины тэр үеийн нийт орлогын 10 хувийг борлуулалтын болон захиалгын орлого, дөнгөж 3%-ийг нь реклам, сурталчилгаа, 87%-ийг нь бусад тэтгэлэг, дэмжлэг туслалцаа эзэлж байжээ².

2006 оны байдлаар авч үзэхэд орон нутагт хэвлэгдэж байсан сонины тоо нэмэгдээгүй ч гаралт нь тогтмолжиж, долоо хоног тутмын, 10 хоног тутмын сонинууд зонхилж, сар тутмын сонинууд 14 хоног тутмын болж, 14 хоног тутмын сонинууд 10 хоног тутмын давтамжинд шилжих үйл явц ид өрнөж байна.

Сонины давтамж ойртож, тогтмолжих тусам реклам, сурталчилгааны

эзлэх хувь илт нэмэгдэж байгаа нь ажиглагдаж байна. Орхон аймгийн нийгэм, улс төр, мэдээллийн 7 хоног тутмын хэвлэл "Шинэ мэдээ" сонин гэхэд 2005 онд уншигчиддаа хүргэх 48 дугаараас 4 дугаар илүү гаргаж, уншигчиддаа бэлэг барьсан бөгөөд 2006 онд ихэнх дугаараа 8 нүүрээр бэлтгэж, 2007 оноос 7 хоногт 2 дугаар гаргахаар бэлтгэж байна.

Дорнод аймгийн "Дорнод", Сэлэнгэ аймгийн "Сэлэнгийн мэдээ", Завхан аймгийн "Завхан", Ховд аймгийн "Ховдын мэдээ", Өмнөговь аймгийн "Монгол говь", Архангай аймгийн "Архангайн мэдээ", Хөвсгөл аймгийн "Далай ээж", "Эрх чөлөө" сонинууд 10 хоног тутам тогтмол гарч, захиалагчдын тоогоо багагүй нэмэгдүүлж, нийтлэлийн чанараа сайжруулан редакцийн үйл ажиллагаа нь тогтмолжиж байна. Тэдний араас Булган аймгийн "Булганы мэдээ", Дундговь аймгийн "Хадаг", "Говийн амьдрал", Сэлэнгэ аймгийн "Шинэ гэгээ", Сүхбаатар аймгийн "Шинэ Сүхбаатар", Увс аймгийн "Увсын амьдрал", "Өнөөдөр Увс", Баян-Өлгий аймгийн "Жана Дэур", Говь-Сүмбэрийн "Чойр 54", Төв аймгийн "Төв Таймс", Баянхонгор аймгийн "Баянхонгор таймс", "Баянхонгорын мэдээ" сонинууд аймгийнхаа ард иргэдийг мэдээллээр хангах, хариуцлагатай бөгөөд хүндтэй үүргээ биелүүлсээр байна.

Харин "Нутгийн амьдрал", "Цахиур Төмөр", "Өвөрхангайн амьдрал" сонинууд гарахаа больж, сураг тасарснаар

Дорноговь, Говь-Алтай, Өвөрхангай аймгууд тогтмол сонингүй аймгуудын жагсаалтыг тэргүүлэх боллоо.

Б. Орон нутгийн радио. Нэг үеийг бодвол радио орон нутгийн мэдээллийн хэрэгслийн урсгалд хүчтэй түрэн орж ирлээ. Бүс нутгийн радио нь Өмнөговь, Говь-Алтай, Хөвсгөл аймгаас нэвтрүүлгээ цацаж, хэдхэн жилийн өмнө гэхэд орон нутгийн радио гэсэн нэр томъёо бараг байхгүй байсан бол одоо олонх аймагт FM радио бий боллоо.

2004 оны судалгааны дүнгээс үзвэл орон нутагт 27 FM радио ажиллаж байгаа гэсэн тоо байна. Үүнээс хойш зарим аймагт нээгдсэн радиог оролцуулан тооцвол 30-35 FM радио орон нутагт тогтмол нэвтрүүлгээ цацаж байна³.

Энэ бол мэдээллийн бага биш багтаамж боловч нэвтрүүлгийн цацалтын хүрээ аймгийн төв орчмоос хэтэрч чадахгүй байгаа юм.

Нөгөө талаар бэлтгэгдсэн сэтгүүлч боловсон хүчин тийм ч хангалттай биш байгаагаас FM радиогийн мэдээллийн болон сэтгүүл зүйн төвшинд бэлтгэгдсэн нэвтрүүлгийн эзлэх хувь нэн бага, голчлон дуу хөгжим, орон нутгийн зар сурталчилгаанд нэвтрүүлгийн ихэнх цагийг зориулж зарим FM радио ерөөсөө

мэдээллийн цаггүй байгааг зөвтгөх аргагүй.

FM радио гэсэн мэдээллийн хэрэгслийн энэ сайхан боломжийг бүрэн дүүрэн ашиглаж, сонсогчдоо соронздон татсан, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн тулгамдсан асуудлын учир шалтгаан, шийдвэрлэх арга замыг нээн харуулсан нэвтрүүлэг явуулахад тэнд ажиллаж байгаа сэтгүүлч, уран бүтээлчдийн идэвх санаачлага, авьяас чадварыг зориулах хэрэгтэй.

«
Нэг үеийг бодвол радио орон нутгийн мэдээллийн хэрэгслийн урсгалд хүчтэй түрэн орж ирлээ. Бүс нутгийн радио нь Өмнөговь, Говь-Алтай, Хөвсгөл аймгаас нэвтрүүлгээ цацаж, хэдхэн жилийн өмнө гэхэд орон нутгийн радио гэсэн нэр томъёо бараг байхгүй байсан бол одоо олонх аймагт FM радио бий боллоо.

»

Орон нутагт ажиллаж байгаа FM радио нь төр захиргаа, төслийн байгууллага болон улс төрийн намын харьяалалд байж нэлээд цагийг тухайн байгууллагын сурталчилгаанд зориулдаг нь нууц биш. Гэхдээ үүнийг 100 хувь буруутгах аргагүй. Ямар ч байсан орон нутагт мэдээллийн "цаасгүй сонин" болсон FM радио хүрээгээ тэлж байгаа нь гол үзүүлэлт мөн.

Дараа нь тэдгээрийн цацаж буй нэвтрүүлгийн чанар чансааг сайжруулах, бие даасан асуудлыг шийдвэрлэх, сэтгүүлч боловсон хүчнийг нь чадваржуулах тухай зэрэгцүүлэн ярих цаг болж байна.

В. Орон нутгийн телевиз. Орон нутагт телевизүүд байгуулагдаж, ихэнхдээ төр захиргааны байгуул-

лагуудын мэдээ мэдээлэл, бодлого үйл ажиллагааг сурталчилсан нэвтрүүлгийг цацаж эхэлсэн нь нэлээд хэдэн жилийн өмнөх түүх юм.

Нийгмийн амьдрал түргэн хурдацтай өөрчлөгдөхийн хэрээр эдгээр телевизүүдийн нэвтрүүлгийн чанар чансаа, нэр төрөл алхам алхмаар сайжирч байгааг тэмдэглэх нь зүйтэй. ОНХМХ-оос хийсэн судалгаанаас үзвэл 37 телевиз өнөөдөр орон нутагт ажиллаж байна. Тэдгээрийн ихэнх нь буюу 85 хувь нь төр захиргааны байгууллагын харьяатай байгаа нь нэн даруй хувьчлах, ингэхдээ тухайн телевизийн тоног төхөөрөмжийг тэнд ажиллаж байгаа сэтгүүлчдэд менежементийн гэрээгээр хувьчлах шаардлагатайг харуулж байна.

Нэгэнт өмч хөрөнгийн ч, удирдлагын ч харьяаллын хувьд бие даагаагүй цагт тэдгээр телевизийн хараат бус бие даасан байдал, нэвтрүүлгийн уран сайхны болон сэтгүүл зүйн төвшний тухай ярихад нэн бэрхшээлтэй байгаа юм.

Мөн зарим аймагт улс төрийн намын харьяалалтай телевиз ч ажилладаг. Эрдэнэт, Дархан зэрэг томоохон хотууд, Хөвсгөл зэрэг томоохон аймгуудад хэд хэдэн телевиз зэрэгцэн зах зээлийн чөлөөт өрсөлдөөн дунд эрчимтэй ажиллаж байхад ихэнх аймгуудад ганц нэг телевиз арай ядан үйл ажиллагаагаа явуулж байна. Арай ядан гэсний учир нь:

1-рт, аймгийн төвд зах зээл жижиг учир өөр телевизүүд үүсэх боломжгүй.

2-рт, байгаа ганц телевиз нь аймгийн ИТХ-ын харьяанд төсвийн цөөн мөнгөнд уяатай.

3-рт, нэгэнт орон нутгийн төсвөөс санхүүжин өмчин дээр нь үйл ажиллагаагаа явуулж байгаа тул бие даасан зах зээлийн менежментээр ажиллах боломж хаалттай гэсэн үг.

Ийм нөхцөлд орон нутгийн телевиз, радиогийн ажиллах хууль эрх зүйн орчин, өмчийн асуудлыг шийдэхгүйгээр тэдний хөгжлийн хараат бус байдлын тухай ярих боломжгүй юм.

Тулгамдсан асуудлууд, цаашдын зорилт

Ийнхүү орон нутгийн хэвлэл мэдээллийн хөгжилд нааштай ахиц дэвшил байгаа боловч тулгамдсан асуудал, бэрхшээлүүд багагүй байна. Эдгээр бэрхшээл хүндрэлүүдийг доорх чиглэлд багцалж болох юм. Үүнд:

1. Хөдөөгийн хүн амын амьжиргааны төвшин доогуур, дэд бүтцийн хөгжил сул, хот хөдөөгийн ялгаа их байгаа нь гол бэрхшээлийн нэг болж байна.

2. Хөдөөд хүн ам сийрэг суурьшдаг тул зах зээл бага, хэвлэл мэдээллийг амьдрал ахуйдаа хэрэглэх чадвар муу байдаг.

3. Хөдөөд ялангуяа аймгаас сумд, сумаас багт, багаас өрхөд хэвлэл шуудан хүргэх хуучин тогтолцоо үгүй болсон. Одоо ч шаардлагын төвшинд хүрч чадахгүй байгаа.

4. Орон нутагт мэргэжлийн сэтгүүлчид, боловсон хүчний хүрэлцээ

муу, тэднийг сургах, суурьшуулах механизм алдагдсан.

5. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль орон нутагт хэрэгжихгүй, хууль эрх зүйн таатай орчин одоо хүртэл бүрэлдэн тогтож чадахгүй байна.

Эдгээр тулгамдсан асуудлуудыг дэс дараатай шийдвэрлэх нь орон нутгийн хэвлэл мэдээллийн цаашдын хөгжлийг тодорхойлох гол арга зам юм.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны үйл ажиллагаа чухамхүү энэ асуудлыг шийдвэрлэхэд л чиглэгдэх ёстой. Тус төрийн бус байгууллагын ойрын зорилтууд ч үүнд чиглэгдэж байгаа билээ. Тухайлбал,

1. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмжих томоохон төсөл боловсруулж хэрэгжүүлэх,

2. Аймгуудын радио, телевизийн статусын асуудлыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулинд нийцүүлэн шийдвэрлэх,

3. Ойрын хоёр жилд багтаан бүх аймгийг тогтмол хэвлэлтэй болгох,

4. Мэргэжлийн сэтгүүлчдийг бэлтгэх, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах таатай нөхцлийг бүрдүүлэх, урамшлын хөшүүрэг бий болгох,

5. Аймгуудын хэвлэл мэдээллийн ажилтнуудын бүсийн уулзалт, редакцийн сургалт, семинаруудыг зохион байгуулах, харилцан туршлага солилцох,

6. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байдалд судалгаа хийх, судлаачид, эрдэмтдийн анхаарлыг орон нутгийн

хэвлэл мэдээлэл рүү хандуулах, хамтарсан онол-практикийн бага хурал, уулзалтуудыг зохион байгуулах зорилтуудыг өмнөө тавьж ажиллаж байна.

Ишлэл

¹ ХЗЯ-ны архив.

² 2001. Монголын хэвлэл мэдээллийн мониторинг. МХХ, УБ.

³ 2004. Монголын хэвлэл мэдээллийн мониторинг. МХХ, УБ.

Ашигласан ном, хэвлэл

1. З у л ь к а ф и л ь М. 1989. Некоторые проблемы повышения эффективности выступления местной партийной печати (1981-1988 гг.). Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. УБ.

2. З у л ь к а ф и л ь М., Б о л д - Э р д з - н э Б. 2000. Монголын сонинны тойм.

3. 2000-2004. Монголын хэвлэл мэдээллийн мониторинг. МХХ, УБ.

4. 2001. Орон нутгийн хэвлэл мэдээлэл ба мэдээлэл авах орчин. Семинарын тайлан. МХХ, УБ.

5. 2004. Орон нутгийн хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал, тэдний хараат бус байдлыг хангах арга замууд. Уулзалт семинарын тайлан. Эрдэнэт.

6. 2006. Орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтнуудын улсын анхдугаар зөвлөлгөөний тайлан. УБ.

7. Ц э р э н ж а в Д. 1998. Монголын сонинуудын тойм.